



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/109

Зуунмод

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр 29.1.9 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нийт нутгаар өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан малчдад туслах сайн үйлсийн аяныг 2024 оны 02 дугаар сарын 19-нөөс 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр хүртэл 1 сарын хугацаанд зохион байгуулсугай.

2.Сарын аяны хүрээнд хандивлаж байгаа тусламжийн бараа материал эд хөрөнгийг бүртгэж хүлээн авч малчдад хүргүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Гантулга)-т, санхүүгийн тайлан тооцоо гаргахыг Төв аймаг дахь улаан загалмайн хорооны дарга (Б.Отгончимэг), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Гантулга) нарт даалгасугай.

3.Хандивлаж байгаа мөнгөн хөрөнгө, бараа материал эд хөрөнгийг олон нийтэд ил тод шилэн байдлаар мэдээлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийн ахлах ажилтан (Э.Ганхуяг)-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын шуурхай штабын нарийн бичгийн дарга (Г.Мөнхбаатар)-т даалгасугай.

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ
ШТАБЫН ДАРГА БӨГӨӨД ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Г.СУРМАА

